

ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК

Улаанбаатар хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн төсөл

Улс орон:	Монгол Улс
Төслийн дугаар:	46383
Бизнесийн салбар:	Хот суурин, байгаль орчин дэд бүтэц
Мэдэгдлийн хэлбэр:	Төр
Байгаль орчны ангилал:	IESE
Захирлуудын Зөвлөлд танилцуулах:	2016 оны нэгдүгээр сарын 27
Өнөөгийн байдал:	Концепцийн Хурлаар батлагдсан, Эцсийн Хурлаар орохоор бэлтгэж байгаа
Төслийн хураангуйг нээлттэй болгосон:	2015 оны 11 дүгээр сарын 17

Төслийн танилцуулга

ЕСБХБ Улаанбаатар хот (цаашид “Хот” гэх)-ын бохир ус цэвэрлэх үйлчилгээний өргөтгөлийг санхүүжүүлэх зорилгоор тус хотын эзэмшдэг ус цэвэрлэх байгууллага болох Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар (цаашид “Компани” гэх)-т дамжуулан зээлдэх 12 сая евроны зээлийг Улаанбаатар хотод олгох асуудлыг судалж байна.

Олон улсын санхүүгийн нэг байгууллага 10 сая хүртэлх евроны хамтын санхүүжилт хийнэ гэсэн хүлээлт байгаа. Дээр нь, ЕСБХБ төслийн санхүүгийн багцыг бүрэн бүрдүүлэх зорилгоор олон улсын хандивлагч байгууллагаас 2 сая евроны хөрөнгө оруулалтын буцалтгүй тусламж авахаар ажиллах болно.

Зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгийг Улаанбаатар хотын аж үйлдвэрийн хөгжлийн шинэ бүсэд бохир ус цэвэрлэх байгууламж, сүлжээ системийг барьж байгуулах ажлыг санхүүжүүлэхэд зарцуулах юм.

Төслийн зорилго

Энэхүү хөрөнгө оруулалт нь бохир ус цэвэрлэх үйлчилгээг өргөтгөх боломжийг Хотод олгох бөгөөд бохир ус цэвэрлэх чанарын түвшинг Европын Холбооны стандартад нийцүүлэх зорилготой. Төслийн амжилтыг хэмжин тодорхойлох зорилгоор Банк төслийн хэрэгжилтийн өмнөх болон дараахь үеийн доорхь үзүүлэлтүүдэд хяналт тавиж ажиллана. Үүнд:

- Жилд цэвэрлэсэн бохир усны хэмжээ, куб метрээр
- Ус цэвэрлэх үйлчилгээнд хамрагдаж буй нийт хүн ам

Шилжилтийн үр нөлөө

Шилжилтийн үр нөлөөллийн асуудлаар Төслөөс дараахь зорилт тавьж ажиллана. Үүнд:

- Тарифын шинэчлэл: Ус хангамж болон бохир ус цэвэрлэх үйлчилгээний үнэ тариф нэмэгдэх болно. Компани тарифын аргачлал, түүний хэрэгжилтийг зохицуулан тохируулна.

- Арилжааны хэлбэрт оруулах: Төсөл нь Компаний хөгжил, оролцогч талуудын оролцооны хөтөлбөрийн хүрээнд техникийн хамтын ажиллагаа явуулах арга замаар арилжааны хэлбэрт оруулахын ач холбогдлыг Монголд харуулж үлгэр жишээ болсноор эерэг үр нөлөө үзүүлэх болно.
- Шинэ болон дахин давтагдах бүтээгдэхүүн: Энэхүү Төсөл нь Монгол дахь хот, орон нутгийн түвшинд хийж буй анхны хөрөнгө оруулалтын төсөл учир үлгэр жишээ болж Монголд эерэг нөлөө үзүүлэх болно.
- Байгаль орчны стандарт сайжрах: Төсөл нь Хотын хүн амын эрүүл мэндийн эрсдлийг бууруулж, Европын Холбооны стандартын дагуу байгаль орчны бохирдлоос сэргийлнэ.
- Ил тод байдал нэмэгдэх: Төслийн үр дүнд ил тод байдал, засаглалын стандарт сайжирна.

Үйлчлүүлэгчийн талаархи мэдээлэл

Улаанбаатар хот

ЕСБХБ-ны Санхүүжилтын тойм

12 сая евро

Төслийн нийт өртөг

26 сая евро

Байгаль орчин, нийгмийн талаархи тойм

Банкны байгаль орчин, нийгмийн мэргэжилтнүүд төслийн газар очиж ажиллах, Нэн тэргүүний хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн цар хэмжээг хянан үзэх зэргээр хийсэн Байгаль орчин, нийгмийн анхан шатны шалгалт судалгааны дагуу Банкны 2008 оны Байгаль орчин, нийгмийн харилцааны бодлогод нийцүүлэн, "Б" ангиллалд оруулав.

Бохир ус цэвэрлэх орчин үеийн хоёр шинэ байгууламж, холбогдох сүлжээний системийг төлөвлөгдөж байгаа Эмээлтийн аж үйлдвэрийн паркийн бүрэлдэхүүнд барьж байгуулснаар Хотын хамгийн их бохирдол үүсгэдэг үйлдвэрийн газруудыг хүн ам шигүү оршдог төв хэсгээс нүүлгэн шилжүүлж, холбогдох үйлдвэрийн газруудын хаягдал усыг зохих түвшинд цэвэрлэн, ингэснээр одоогийн аж үйлдвэрийн бүс газрын орчинд оршин суудаг хүн амын эрүүл мэндийн эрсдлийг бууруулан, муу цэвэрлэгдсэн хаягдал уснаас хөрс болон хөрсөн дээрх усны нөөц бохирдох явдлыг ихээхэн багасгаж, улмаар Хотод байгаль орчин, нийгмийн ашиг тусаа өгнө гэж тооцож байна.

Техник, эдийн засгийн үндэслэлийн салшгүй нэг хэсэг болох Байгаль орчин, нийгмийн судалгаа шинжилгээ (ESDD) одоо хийгдэж байгаа бөгөөд үүнд Компаний менежментийн тогтолцоо, одоогийн байгууламж, үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн аудит, үнэлгээ; Төслийн зүгээс ЕСБХБ-ны Үйл ажиллагааны шаардлагуудыг биелүүлэх явдлыг хангах зорилгоор нэн тэргүүний хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн нөлөө, үр ашигт хийх байгаль орчин, нийгмийн харилцааны анализ багтаж байна. Газар шилжүүлэн (худалдан) авах, түүнтэй холбоотой иргэдийг нүүлгэн шилжүүлэх, аж амьдралд нь нөлөө үзүүлэх магадлал, барилгын ажил, үйл ажиллагааны үе шатанд олон нийтийн болоод ажиллагсадд учирч болох эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудал, цэвэрлэх байгууламж (WWTP)-ийн үйл ажиллагааны үр ашиг болон хаягдал усны чанар, хөрсөн дээрх ус руу урсгах байдал, лагийн хаягдалд менежмент хийх шийдэл, тарифын уян

хатан байдал, ажиллагаанд оролцогчдын жендерийн тэгш байдлыг хангасан оролцоо зэрэг асуудлаархи Монгол болон ЕХ-ны стандартыг хангах чадвар зэрэг асуудал судалж байгаа үндсэн асуудлуудын тоонд орж байна.

Банкны Үйл ажиллагааны шаардлагуудыг боломжит цаг хугацааны хүрээнд ханган биелүүлэх зорилгоор өмнөх судалгаа шинжилгээний явцад илрүүлсэн байгаль орчин, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх, Төслийн онцлогтой Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны хөтөлбөр (ESAP)-ийг боловсруулж ажиллана. Компаний зүгээс холбогдох Талуудын оролцооны төлөвлөгөө (SEP) гаргаж, түүндээ өргөдөл гомдол хүлээн авч шийдвэрлэх механизмын асуудлыг тусгана.

Төслийн хураангуйг нээлттэй болгосон энэхүү мэдээллийг судалгаа шинжилгээний ажлын үр дүн тодормогц шинэчлэн гаргана.

Техник хамтын ажиллагаа

Зээлийн гэрээнд гарын үсэг зурахаас өмнөх баримт бичгүүд:

- ТХА 1: Техник, эдийн засгийн үнэлгээ, түүний дотор санхүү, эдийн засаг, техникийн болоод байгаль орчин, нийгмийн судалгаа шинжилгээ. Энэ ажлын анхны өртөг нь Японы Засгийн газраас санхүүжих 279,958 евро байсан бөгөөд дараа нь 25,495 еврогоор нэмэгдсэн нь Банкны дотоод эх үүсвэрээс санхүүжүүлсэн юм.
- ТХА 2: Хотын зээлжих чадварын талаархи дүн шинжилгээ. Энэхүү ажлын өртөг нь Банкны дотоод эх үүсвэрээс санхүүжүүлсэн 31,977 евро.

Зээлийн гэрээнд гарын үсэг зурахын дараах баримт бичгүүд:

- ТХА 3: Төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх. Энэ ажлын өртөг нь 1,000,000 евро байх бөгөөд олон улсын хандивлагч болон ЕСБХБ-ны Шилжилтийн эхэн үеийн орнууд (ETC)-ын сан, эсвэл Хувьцаа эзэмшигчдийн тусгай сан (SSF)-гаас санхүүжүүлэх санал тавьж буй.
- ТХА 4: Компаний хөгжил, талуудын оролцооны хөтөлбөр. Компаний бүтцийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, Талуудын оролцоог хангах хөтөлбөр (SPP)-ийг хэрэгжүүлэх, Компаний данс тооцоог Олон улсын санхүүгийн тайлан гаргах стандарт (IFRS)-ын дагуу дахин гаргах, аудит хийх зорилготой. Ажлын өртөг нь 500,000 евро байх тооцоотой бөгөөд олон улсын хандивлагч, ETC сан, эсвэл SSF-ээс санхүүжүүлэх саналтай байгаа.

Компаний хариуцагчийн мэдээлэл

Ноён Сандагдоржын Баярбаатар

bayarbaatar@ulaanbaatar.mn

+976 11 325060

Их Чингис Хааны талбай 11

Улаанбаатар 46, Монгол Улс

Бизнес боломжууд

Бизнесийн боломж, худалдан авалтын талаар үйлчлүүлэгч байгууллагад хандана уу.

Ерөнхий мэдээлэл авах

Худалдан авалтаас бусад асуудлаар ЕСБХБ-ны төслийн тухай мэдээлэл авах:

Утас: +44 20 7338 7168; Факс: +44 20 7338 7380

И-мэйл: projectenquiries@ebrd.com

Олон нийтийн мэдээллийн бодлого (PIP)

Олон нийтийн мэдээллийн бодлого нь ЕСБХБ-ны стратеги, бодлого, үйл ажиллагааг илүү мэдүүлж, ойлгуулах зорилгоор мэдээллийг хэрхэн ил болгох, талуудтай хэрхэн зөвлөлдөхийг тодорхойлдог.

<http://www.ebrd.com/pages/about/what/policies/pip.shtml>

Төслийн холбогдолтой санал, гомдлыг авч үзэх механизм (PCM)

ЕСБХБ нь Төслийн холбогдолтой санал гомдлыг авч үзэх механизм (PCM) бий болгон ажилладаг бөгөөд нэг буюу хэсэг хүмүүс, байгууллагаас Банкны санхүүжилт хийсэн төслүүдээс үүдэлтэй хохирол гарсан, гарах магадлалтай тухай гомдлыг бие даасан, хараат бусаар хүлээн авч үзэх боломж олгодог.

<http://www.ebrd.com/documents/occo/project-complaint-mechanism-pcm-rules-of-procedure.pdf>

PCM механизмд хамаарах аливаа гомдлыг ЕСБХБ-ны хөрөнгийн хамгийн сүүлийн хуваарилалтаас хойш 12 сарын дотор гаргах ёстой. Таны гомдол аль хугацаанд хамаарах талаар мэдэхгүй байгаа бол PCM хариуцсан ажилтантай (pcm@ebrd.com хаягаар), эсвэл ЕСБХБ-ны Суурин төлөөлөгчийн газартай холбогдож, тусламж хүснэ үү.